

The logo for Mongolian Re, featuring the word "Mongolian" in white on a dark blue background and "Re" in white on a red background.

Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ

A collage of financial data including a bar chart with numbers 1-13, a line graph, and various coins and banknotes.

ЖИЛИЙН ТАЙЛАН 2023

A close-up photograph of two hands shaking in a firm grip, symbolizing a business agreement or partnership.

УЛААНБААТАР ХОТ



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Сайн байцгаана уу,

Үндэсний давхар даатгал ХК-ийн хувьд өнгөрч буй 2023 он ололт амжилт, өсөлт, зорилго тэмүүлээр дүүрэн, тавьсан зорилтдоо хүрсэн өрнүүн жил боллоо. Бид дотоодын тэргүүлэх давхар даатгагчийн хувьд улсын санхүүгийн тогтвортой байдал, эдийн засгийн тогтвортой хөгжилд бодит хувь нэмрээ оруулсан нэгэн жилийг үдэж байна. Өсөн нэмэгдэж буй зах зээлийн шаардлагад нийцүүлэн давхар даатгалын үйлчилгээг үзүүлж ирснээр 9 жилийн хугацаанд нийт хөрөнгөө 70 тэрбумд хүргэж, цэвэр хураамжийн орлого сүүлийн 5 жилд 25.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Бид компанийн үндсэн үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө, үйл ажиллагааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн болон чанарын бодлогыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд үйл ажиллагаандаа ISO стандартыг нэвтрүүллээ.

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч AM Best агентлагаас манай компанийг ерөнхий санхүүгийн чадавх В, урт хугацааны зээлжих зэрэглэл ВВ+, цаашдын төлөвийг “Тогтвортой” гэж үнэллээ. Энэ нь биднийг олон улсын стандартын дагуу бүтээгдэхүүн, үйлчилгээгээ харилцагчдадаа хүргэдгээс гадна хөрөнгө, эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэн ажилладаг чадварлаг баг хамт олон гэдгийг илтгэж байна. Тодруулбал, балансын чадавхын хувьд “very strong” буюу “маш өндөр”, үйл ажиллагааны гүйцэтгэл, эрсдэлийн удирдлагыг “хангалттай” хэрэгжүүлэн ажилладаг гэж дүгнэсэн. Мөн компанийн өнгөрсөн жилүүдийн гүйцэтгэл, ирэх жилийн стратеги болон бизнес төлөвлөгөөг үндэслэн Монгол Улсын даатгалын салбарын хөгжилд чухал үүрэг, оролцоотой компани болохыг онцлон дурдсан. Улмаар бид цаашид давхар даатгалын үйлчилгээг дан ганц дотооддоо үзүүлэх бус олон улсад үзүүлэх нөхцөл бүрдэж буйгаас гадна гадаадын түншлэлийг улам бэхжүүлэх замаар Монгол Улсын даатгалын салбарын хөгжил, эдийн засгийн төрөлжилтэд оруулж буй хувь нэмрээ улам сайжруулна гэдэгтээ итгэлтэй байна.

Бид 2023 онд үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй найдвартай байдлыг ханган давхар даатгалын үйлчилгээгээ үзүүлж, 5 тэрбум гаруй төгрөгийн нөхөн төлбөрийг олголоо.

Уур амьсгалын өөрчлөлт, эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдлын нөлөөгөөр эрсдэлийн цар хүрээ, хэмжээ, далайц улам бүр өргөжиж, нийгэмд шинэ сорилтууд тулгарсаар байна. Өсөн нэмэгдэж буй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг шилжүүлэх үйлсэд давхар даатгалын оролцоо хамгийн чухлаар тавигдах болсон. Ийм нөхцөлд бид үйл



ажиллагааны орлогоо эрчимтэй өсгөн, хөрөнгө санхүүгийн чадавхаа улам бэхжүүлж, зөв удирдан, чадварлаг мэргэшсэн хүний нөөц, удирдлагын арга барилаар андеррайтингийн чадавх, эрсдэл даах чадамжаа тасралтгүй сайжруулан, та бүхнийг эрсдэлээс хамгаалж, эрсдэлийг шилжүүлэн ажилладаг.

Бид цаашид ч мөн харилцагч, хувьцаа эзэмшигч, хамт олон, нийгмийн дунд үнэ цэнээ хадгалан давхар даатгалын ирээдүйн өсөлт, шилжилтэд чиглэн ажиллана. Улсын эдийн засаг, тогтвортой байдалд чухал ач холбогдол бүхий стратегийн бүтээгдэхүүн үйлчилгээг даатгалын компаниудтай хамтран зах зээлд нийлүүлэх, эрсдэлийн төрөлжилтөнд хурдан хариу өгөх, шинэ технологи, нөү-хау, чадварыг нэвтрүүлэх, шинэ сорилтууд, олон талт байдалд нийцүүлэн хүний нөөцийн чадавхаа улам бэхжүүлэх, байгууллагын хөрөнгө санхүүг тасралтгүй өсгөх замаар улсын, аж ахуйн нэгж болон иргэдийн санхүүгийн тогтвортой байдлыг ямагт ханган ажиллахаа амлаж байна.

Үндэсний давхар даатгал ХК-ийн хамт олноос хамтран ажиллагч эрхэм түнш байгууллагууд, эрхэм үйлчлүүлэгчдэдээ чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

Та бүхэндээ сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



Үндэсний давхар даатгал ХК нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, валютын гадагшлах урсгалыг бууруулах, олон улсын стандартад нийцсэн давхар даатгалын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор 2014 онд байгуулагдсан төрийн өмчит хувьцаат компани юм.

Бид олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч AM Best агентлагаас ерөнхий санхүүгийн чадавхын хувьд В, урт хугацааны зээлжих зэрэглэлийн хувьд ВВ+, цаашдын төлөвөө “Тогтвортой” үнэлгээ авсанаас гадна компанийн үндсэн үйл ажиллагааг дэмжих, компанийн хөрөнгө, үйл ажиллагааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн болон чанарын бодлогыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд компанийн үйл ажиллагаандаа ISO стандартыг нэвтрүүлэн ажиллаж байна.

Бид олон улсын стандартад нийцсэн давхар даатгалын үйлчилгээг үзүүлэн ажиллахдаа олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудын хамгийн өндөр үнэлгээ бүхий дэлхийн шилдэг давхар даатгалын компаниудтай хамтран ажиллаж харилцагчдынхаа эрсдэлгүй байдлыг ханган ажиллаж байна.



АЛСЫН ХАРАА

Бид Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэн, ашигт ажиллагааг дээдлэгч, Төв Азийн тэргүүлэх давхар даатгагчдын нэг, Мэргэшлийн дээд түвшний стандартыг тогтоогч, Монгол Улсын давхар даатгалын жишиг компани, Мэргэжлийн хөрөнгө оруулагч болно.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид үйлчлүүлэгчдийнхээ хөрөнгө, санхүүгийн эрсдэлгүй найдвартай байдлыг ханган давхар даатгалын үйлчилгээ үзүүлж, үндэсний давхар даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.



ҮНЭТ ЗҮЙЛС

Үндэсний давхар даатгал хк-ийн алсын хараа, эрхэм зорилгод тусгасан зорилго, чиглэл, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дараах үнэт зүйлсийг мөрдлөг болгон ажиллана.


МЭРГЭШСЭН ӨНДӨР ЧАДАВХ: Даатгалын мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчин

МАНЛАЙЛАЛ: Цаашдын зорилго, зорилтыг тодорхойлон бусдад үлгэрлэх, чиглүүлэн нэгтгэх, хамтдаа бодит үйл хэрэг болгоно.

ХАМТЫН ЗУТГЭЛ: Бусадтай хүндлэлтэй хандаж, итгэлцэл бий болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажиллаж бүтээмжийг нэмэгдүүлнэ.

ҮНЭНЧ ШУДАРГА ЗАРЧИМ: Монгол Улсын хууль тогтоомжийг чандлан мөрдөж, Үндэсний давхар даатгал ХК-ийн ёс зүйн дүрмийг өдөр тутамд мөрдлөг болгон ажиллана.

ИЛ ТОД ХАРИЛЦАА ХОЛБОО: Мэдээллийн ил тод байдлыг хангах үүргээ биелүүлж, шударга, нээлттэй харилцаа холбоо тогтооно.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМУУДЫН ХЭРЭГЖИЛТ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Компанийн тухай хуульд заасны дагуу “Үндэсний давхар даатгал” ХК-ийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчид (ХЭ)-ийн хурал байна. ХЭ-ийн хурлын бүрэн эрхийг Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасны дагуу санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн буюу Сангийн сайд хэрэгжүүлдэг.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Компанийн тухай хуулийн 75.1, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21.2-т заасны дагуу ХЭ-ийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) юм. Компанийн тухай хууль, компанийн дүрэмд зааснаар ТУЗ 9 гишүүнтэй бөгөөд тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байдаг. ТУЗ бүрэн эрхээ Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21.2 болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэн ажилладаг.

ТУЗ нь үйл ажиллагаагаа байнгын, тогтмол, мэргэшсэн байдлаар зохион байгуулах зорилгоор дэргэдээ “Аудитын”, “Цалин, урамшууллын”, “Нэр дэвшүүлэх”, “Эрсдэлийн” гэсэн хороодыг байгуулсан.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА


Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйл, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлдэг.

Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулдаг.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс” шинэчлэн батлагдсантай холбогдуулан шаардлагатай дүрэм, журам, бодлогын баримт бичгийг өөрийн компанийн онцлогт нийцүүлэн шинээр болон шинэчлэн боловсруулж, ТУЗ, гүйцэтгэх удирдлагаар батлуулсан. Үүнд:

1. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
 2. ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журам
 3. Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам
 4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх журам
 5. Дотоод аудитын журам
 6. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам
 7. Комплаенсын хяналтын журам
 8. Мэдээллийн ил тод байдлын журам
 9. Ажилтны ёс зүйн дүрэм
 10. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам
 11. Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг
 12. Эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх аргачлал
 13. Залгамж халааны бодлогын баримт бичиг
 14. Ногдол ашигтай холбогдох үйл ажиллагааг зохицуулах журам
 15. Хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагааг зохион байгуулах журам
 16. Цалин, урамшууллын бодлогын баримт бичиг
 17. Ажилтнуудаас гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам
- Эдгээр дүрэм, журам, бодлогын баримт бичиг болон “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.



“ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ (2023 оны 4 дүгээр улирлын байдлаар)					
Д/Д	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ЗАРЧМУУД	ХЭРЭГЖИЛТ	АВАЛ ЗОХИХ НИЙТ ОНОО	ҮНЭЛСЭН ОНОО	ҮНЭЛЭНИЙ ХУВЬ
1	2	3	4	5	6
1	НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ (ТУЗ)-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна	ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН	12	11	91.7%
2	ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ	ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН	10	10	100%
3	ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана	ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН	6	6	100%
4	ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана	ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН	6	6	100%
5	ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплаенсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина	ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН	8	7	87.5%
6	ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна	ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН	6	6	100%
7	ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ	ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН	8	7	87.5%
8	НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно	ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН	6	6	100%
9	ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана	ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАСАН	10	9	90%
НЭГДСЭН ДҮН			72	68	94.4%

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



**Чойжилсүрэнгийн
ТАВИНЖИЛ**

Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга



**Зоригтбаатар
ЭНХБОЛД**

Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга



**Цэндгомбо
БОЛОРЧУЛУУН**

ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга



**Аюуш
ДЭМБЭРЭЛ**

ҮСХ-ны Даргын зөвлөх



**Пүрэвжав
ЭРДЭНЭБААТАР**

Монголын даатгалын холбооны Удирдах зөвлөлийн дарга, "Монре даатгал" ХХК-ийн Гүйцэтгэх захирал



**Даржаа
НАСАНЖАРГАЛ**

"Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо"-ны Удирдах зөвлөлийн гишүүн



**Цогоо
ДАШДОНДОГ**

Хараат бус гишүүн



**Сүхрагчаа
МӨНХТӨР**

Хараат бус гишүүн



**Янжив
БАТХАНД**

Хараат бус гишүүн

Mongolian
ҮНДЭСНИЙ ДАВХАР Д



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Төлөөлөн удирдах зөвлөлийн хороод нь "Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын ажиллах журам"-д заасан тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд тухайн асуудлаар санал, зөвлөмж, үнэлэлт, дүгнэлт гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, хуульд заасан зарим асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй.

Хороод нь дээрх бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаандаа хамтын шийдвэр гаргах, ил тод, шуурхай, хариуцлагатай байх зарчмыг баримтлан байнгын ажиллагаатай ажиллаж байна.



АУДИТЫН ХОРОО

Хорооны дарга – Ц.Дашдондог
Гишүүд – С.Мөнхтөр,
Ц.Болорчулуун

ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

Хорооны дарга – С.Мөнхтөр гишүүд
Гишүүд – Ц.Дашдондог,
А.Дэмбэрэл


НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО

Хорооны дарга – З.Энхболд
Гишүүд – Ц.Дашдондог, С.Мөнхтөр

ЭРСДЭЛИЙН ХОРОО

Хорооны дарга – Я.Батханд
Гишүүд – А.Дэмбэрэл,
П.Эрдэнэбаатар, Д.Насанжаргал

ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС



САНХҮҮГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Тайлант онд компанийн хөрөнгө өмнөх оноос 8.52 хувь буюу **5 тэрбум 61 сая** төгрөгөөр өсч **65 тэрбум 915 сая** төгрөгт хүрсэн нь Монгол Улсын даатгалын салбарын 14 хувийг эзэлж байна.

Даатгалын хураамж өнгөрсөн жилээс 64 хувь буюу **2 тэрбум 644 сая** төгрөгөөр нэмэгдүүлж **6 тэрбум 728 сая** төгрөгийг хуримтлуулсан байна.


НИЙТ ХӨРӨНГӨ /тэрбум төгрөг/ ₮




ДААТГАЛЫН ХУРААМЖ /тэрбум төгрөг/ ₮



НИЙТ ОРЛОГО БА ЦЭВЭР АШИГ /тэрбум төгрөг/ ₮



НӨӨЦ САН /тэрбум төгрөг/ ₮



2023 ОНЫ АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН



БОРЛУУЛАЛТЫН ҮР ДҮН

Үндэсний давхар даатгал ХК нь 2023 онд дотоодын даатгалын компаниудад давхар даатгалын үйлчилгээ үзүүлэн трити, факультатив, фронтинг давхар даатгалын гэрээ байгуулж, нийт 6 тэрбум 728 сая төгрөгийн хураамж төвлөрүүлээ. Компанийн 2022 оны борлуулалтын үр дүнтэй харьцуулахад хариуцлагын даатгал, барилга угсралтын даатгалд огцом өсөлттэй ажиллаж хураамжийн орлого 68.0 хувиар нэмэгдсэн байна.




сая.төг	ХУРААМЖИЙН ОРЛОГО	ХУРААМЖИЙН ОРЛОГО	ХУРААМЖИЙН ӨСӨЛТ ХУВИАР
ДААТГАЛЫН ХЭЛБЭР	2022 он	2023 он	
МАЛ АМЬТДЫН ДААТГАЛ (МИД)	1,296.4	1,691.2	30%
ХӨРӨНГӨ	1,315.1	2,130.8	62%
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ	906.1	1,142.3	26%
АГААРЫН ХӨЛГИЙН ДААТГАЛ	127.2	102.6	
ХАРИУЦЛАГА	165.4	394.6	465%
БАРИЛГА УГСРАЛТ	49.5	329.3	565%
БУСАД	220.9	397.8	30%
НИЙТ	4,008.1	6,728.6	68%



ХУРААМЖИЙН ОРЛОГЫН ХАРЬЦАА

ДААТГАЛЫН ҮНДСЭН ХЭЛБЭРҮҮДЭЭР 2022-2023 ОН



Хураамжийн орлогын багцын 87 хувийг 4 бүтээгдэхүүн эзэлж байна.



	2022 он	2023 он
МАЛ АМЬТДЫН ДААТГАЛ (МИД)	1,296.4	1,691.2
ХӨРӨНГӨ	1,315.1	2,130.8
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ	906.1	1,142.3
АГААРЫН ХӨЛГИЙН ДААТГАЛ	127.2	102.6
ХАРИУЦЛАГА	165.4	934.6
БАРИЛГА УГСРАЛТ	49.5	329.3
БУСАД	220.9	397.8



МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ /МИД/-ЫН 2023 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ҮР ДҮН



МИД-ын 2023 оны борлуулалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл оролцогч 7 даатгалын компани болох Ард даатгал ХК, Бодь даатгал ХК, МИГ даатгал ХХК, Монгол даатгал ХК, Мөнх даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Хаан даатгал ХХК болон зуучлагч 2 банк болох ХААН банк, Төрийн банктай 8 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хамтран зохион байгуулсан. Дээрх хугацаанд нийт **35,703 малчин** өрхийн, **149 тэрбум** төгрөгийн үнэлгээ

бүхий **7,01 сая толгой малыг** даатгалд хамруулж, нийт 4 тэрбум 965 сая төгрөгийн хураамжийг төвлөрүүлсэн байна. Үүнээс давхар даатгалын хураамжид 1 тэрбум 688 сая төгрөг компанид төвлөрүүлсэн байна. Даатгуулсан малчин өрх нь Монгол Улсын нийт малчин өрхийн **18.9 хувийг**, даатгуулсан мал нь нийт малын 11 хувийг тус тус эзэлж байна.


ТАЙЛАНТ ОН	2021	2022	2023	ӨСӨЛТ, БУУРАЛТ
ДААТГАЛЫН НИЙТ ХУРААМЖ	3,922	3,912	4,965	27%
ДААТГУУЛСАН МАЛЧИН ӨРХ	34,709	27,456	35,703	30%
ДАВХАР ДААТГАЛЫН ХУРААМЖ	1,319	1,296	1,688	30%



МИД хэрэгжсэн 18 жилийн хугацаанд давхардсан тоогоор 329 мянга малчин өрхийн 68.8 сая толгой малыг даатгалд хамруулж, 35 тэрбум 871 сая төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлжээ. Эдгээрээс 59 мянган малчин өрх нийт 12 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр авч, энэхүү даатгалын ач тусыг малчид амьдрал дээр бодитойгоор хүртээд байна.

ДААТГАЛД ХАМРАГДСАН СҮРГИЙН БҮТЭЦ

● ЯМАА ● ХОНЬ ● ҮХЭР ● АДУУ ● ТЭМЭЭ



МИД ЭРСДЭЛ ДААХ ЧАДВАР		
1	Хамтын эрсдэлийн сан	2,234,467,937.25
2	Дунд түвшний эрсдэлийн нөөц сан	3,177,213,509.17
3	Олон улсын давхар даатгалын хариуцлага	6,455,129,596.50
	Дээд түвшний эрсдэлийн нөөц сан	2,269,494,203.08
	Олон улсын давхар даатгалын хариуцлага	2,191,514,964.83
НИЙТ:		16,327,820,210.83

ЭРСДЭЛ ДААХ ЧАДВАР



МИД-ЫН НӨХӨН ТӨЛБӨР

МИД-д 2022 онд даатгуулсан 27,456 малчин өрхийн Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Дархан-Уул аймгуудын нийт 202 сум болон Улаанбаатар хотын 4 дүүргийн **13,930 малчин өрхөд** нийт **4 тэрбум 177 сая** төгрөгийн нөхөн төлбөрийг ҮСХ-ны хагас жилийн мал тооллогын үр дүнд тооцоолон 2023 оны 4-р улиралд олгосон. Нөхөн төлбөр авсан малчин өрх нийт даатгалд хамрагдсан малчин өрхийн **50.7 хувийг** эзэлж байна

НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР



Хөрөнгө, хариуцлага, тээврийн хэрэгслийн даатгал, малын индексжүүлсэн даатгалаар нийт 5 тэрбум 803 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон нь хамгийн өндөр нөхөн төлбөр олгосон жил байлаа.



ХӨРӨНГИЙН ДААТГАЛ

3 тэрбум 200 сая төгрөг

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ, ХҮНД ДААЦЫН МАШИН МЕХАНИЗМИЙН ДААТГАЛ



239.7 сая төгрөг



ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ

152.8 сая төгрөг

	сая төг
ХӨРӨНГӨ	3,150.23
МИД	2,260.09
Тээврийн хэрэгсэл, Хүнд машин механизм	239.75
Хариуцлага	152.83
НИЙТ	5,802.90

ДОТООД ТҮНШЛЭЛ

Компанийн үйл ажиллагааг тэлэх, борлуулалтын сувгийг өргөжүүлэх, сайжруулах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор олон улсын болон дотоодын төр, хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх ажлуудыг хэрэгжүүлэн ажиллалаа.



ГАДААД ТҮНШЛЭЛ



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Компанийн эрсдэлийн засаглал дараах зүйлсээс бүрддэг. Үүнд:

- Хамгаалалтын гурван шугам
- Засаглалын баримт бичгүүд
- Засаглалын хороод

ХАМГААЛАЛТЫН ГУРВАН ШУГАМ

НЭГДҮГЭЭР ШУГАМ: Компанийн газар нэгжийн бүх ажилтан
ХОЁРДУГААР ШУГАМ: Компанийн Эрсдлийн хороо болон Эрсдэл хариуцсан газар нэгж
ГУРАВДУГААР ШУГАМ: Дотоод аудитын алба

ЗАСАГЛАЛЫН БАРИМТ БИЧГҮҮД

Бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны журам, аргачлал хамгаалалтын гурван шугамыг хэрэгжүүлэх баримт бичгүүд ордог.

ЗАСАГЛАЛЫН ХОРООД

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо, Компанийн Эрсдэлийн хороо
 Эрсдлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Компани нь "Хамгаалалтын гурван шугам"-ын зарчим бүхий эрсдэлийн засаглалыг хэрэгжүүлдэг. Энэ нь Компанийн дотоод хяналтын тогтолцоог сайжруулдаг.

ТУЗ/ДОТООД АУДИТЫН АЛБА

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

НЭГДҮГЭЭР ШУГАМ

ХОЁРДУГААР ШУГАМ

ГУРАВДУГААР ШУГАМ

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАДАГ.
 Нэгдүгээр шугам (Компанийн бүх газар нэгжийн ажилтнууд) нь өөрсдийн хяналтын тогтолцооны хүрээнд эрсдэлийг үнэлэх, хянах, тайлагнах, бууруулж ажиллах чиг үүрэгтэй

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАДАГ.
 Хоёрдугаар шугам болох Компанийн Эрсдэлийн хороо болон Эрсдэл хариуцсан газар нэгж нь Нэгдүгээр шугамд чиглэл, зөвлөмж өгөхөөс гадна түүний эрсдэлийг удирдах хяналтын зохион байгуулалт болон ажиллагаанд мониторинг хийдэг.

ХАРААТ БУС БАТАЛГААЖУУЛАЛТААР ХАНГАЖ АЖИЛЛАДАГ.
 Гуравдугаар шугам болох Дотоод аудитын алба нь эрсдэлийг хэрхэн үр дүнтэй үнэлж удирдаж байгаа талаар I болон II шугамын үйл ажиллагааны үр дүнтэй байдалд хараат бус үнэлэлт дүгнэлт өгч ажилладаг.



ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь байгууллагад тулгарч болзошгүй төрөл бүрийн эрсдэлийг тодорхойлох, хэмжих, удирдах, хянах зэрэг үйл ажиллагааны шат дарааллаас бүрддэг бөгөөд уг тогтолцоог хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бодлого, журам, арга аргачлалуудыг боловсруулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Даатгалын үйл ажиллагааны голлох үзүүлэлт болох даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцааг хангаж буй эсэхийг даатгагчийн хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа болон даатгагчийн зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцааг тооцох замаар тодорхойлдог. Компанийн хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа 100 хувиас их буюу нэгдүгээр түвшинд, зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн харьцаа 0-ээс 10 хувь хүртэл буюу нэгдүгээр түвшинд байгаа тул компанийн төлбөрийн чадвар сайн буюу нэгдүгээр түвшинд байна.

ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2021 ОН	2022 ОН	2023 ОН
ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭТ БАЙДЛЫН ХАРЬЦАА (Шалгуур >=100%)	341%	314%	332%
ЗӨВШӨӨРӨГДӨХГҮЙ ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА	1.82%	1%	1.32%
ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	I ТҮВШИН	I ТҮВШИН	I ТҮВШИН
ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА (Шалгуур >=110%)	129.88%	122.23%	129.54%

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

мянган төгрөгөөр	2023 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2022 оны 12 сарын 31- ний үлдэгдэл
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,483,751	1,311,522
Даатгалын авлага болон бусад авлага	2,802,097	449,669
Урьдчилж төлсөн зардал	50,089	365,770
Бараа материал	6,415	5,833
Давхар даатгалын хойшлогдсон хураамж	1,069,695	475,393
Хөрөнгө оруулалт	60,034,259	56,896,723
Эргэлтийн хөрөнгийн дүн	65,446,306	59,504,910
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	170,294	243,326
Биет бус хөрөнгө	254,087	325,923
Ашиглах эрхтэй хөрөнгө	44,524	222,622
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	468,905	791,871
НИЙТ ХӨРӨНГӨ	65,915,211	60,296,781

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

мянган төгрөгөөр	2023 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2022 оны 12 сарын 31- ний үлдэгдэл
Өр төлбөр ба эздийн өмч		
Өр төлбөр		
Санхүүгийн өр төлбөр	1,061,140	406,403
Санхүүгийн бус өр төлбөр	-	866
Хойшлогдсон татварын өр	15,913	20,015
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	2,561,109	1,703,312
Хамтын эрсдэлийн сан	2,285,751	1,907,423
Эрсдэлээс хамгаалах сан	5,379,650	5,446,708
Нөхөн төлбөрийн нөөц сан	4,739,699	3,722,999
Өр төлбөрийн нийт дүн	16,043,262	13,207,726
Эздийн өмч		
Эзэмшигчдийн өмч	24,500,000	24,500,000
Эздийн өмчийн бусад хэсэг	489,264	489,264
Алдагдлаас хамгаалах сан	19,000,000	19,000,000
Хуримтлагдсан ашиг	5,882,685	3,099,791
Эздийн өмчийн дүн	49,871,949	47,089,055
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	65,915,211	60,296,781

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

мянган төгрөгөөр	2023 он	2022 он
Даатгалын хураамжийн орлого	6,728,574	4,084,232
Даатгалын хураамжийн буцаалт	(115,970)	(76,986)
Давхар даатгалын хураамжийн зардал	(2,517,985)	(1,598,286)
Давхар даатгалын цэвэр орлого	4,094,619	2,408,960
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	(857,797)	36,835
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	286,677	130,390
Орлогод тооцсон хураамж	3,523,499	2,576,185
Нийт нөхөн төлбөрийн зардал	(5,802,958)	(184,507)
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	3,891,536	-
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	-	49,263
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	(946,642)	(809,551)
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	(2,861,064)	(944,795)
Хөрөнгө оруулалтын орлого	7,471,095	4,956,652
Бусад даатгалын хураамжийн бус орлого	2,682	85,595
Ерөнхий ба удирдлагын зардал	(4,501,867)	(2,932,081)
Санхүүгийн зардал	(19,042)	(30,431)
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(91,649)	(299,079)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	3,523,654	3,412,046
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ	(740,760)	(498,788)
Тайлант үеийн цэвэр ашиг	2,782,894	2,913,258

Mongolian Re

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ

☎ 7577 0002
✉ info@mongolianre.com
🌐 <http://mongolianre.com/>



📘 <https://facebook.com/MongolianRe>
📷 <https://instagram.com/mongolianreinsurance>
📺 <https://youtube.com/@mongolianre6433>
🌐 <https://linkedin.com/company/mongolian-re/>
🐦 https://twitter.com/Mongolian_Re